








АЖИЛЛАГСАД




Уул уурхайн салбарт ажиллаж байгаа нийт ажиллагсадын 84 % буюу 60720 нь эрэгтэй ажиллагсад байгаа бол 16 % нь буюу 11565 нь эмэгтэй ажиллагсад байна.










Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдээс 2024 оны байдлаар улс, орон нутгийн төсөвт нийт 10.1 их наяд төгрөгийн орлого оруулсан байна. Энэхүү орлогыг 2023 онд оруулсан орлоготой харьцуулахад 38.3%-иар өсжээ.

Уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт 2024 онд оруулсан нийт орлогын хэмжээг ашигт малтмалын төрлөөр авч үзвэл нүүрс олборлогчид 6.7 их наяд төгрөг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж нийт татварын орлогын 67.1%-ийг, зэс үйлдвэрлэгчид 2.3 их наяд төгрөг төлж нийт татварын орлогын 23.0%-ийг, алт, цайр, төмөр болон бусад ашигт малтмал олборлогчид 1.0 их наяд төгрөгийг төлж нийт татварын орлогын 9.9%-ийг бүрдүүлсэн байна.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого, тэрбум.төг /татварын төрлөөр/




Уул уурхайн салбараас улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын хэмжээг татвар, төлбөрүүдийн төрлөөр авч үзвэл Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 4.7 их наяд төгрөг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 4.0 их наяд төгрөгийг тус тус төлснөөр татвар төлөлтийн ихэнх хэсгийг эзэлж байна.

Улс, орон нутгийн төсөвт 2024 онд төвлөрүүлсэн нийт орлогод Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 46.5%, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 40.1%, Хувь хүний орлогын албан татвар 5.0%, Нэмэгдсэн өртгийн албан татвар 2.4%, Ус ашигласны төлбөр 0.7%, Агаарын бохирдлын төлбөр 0.8%, Газрын төлбөр 0.5%, бусад татвар төлөлт 4.0%-ийг тус тус эзэлж байна.

УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН

Төлөвлөгөө ирүүлсэн байдал



Тайлан ирүүлсэн байдал

